# ГОВЬСҮМБЭР АЙМАГ
# ШИВЭЭГОВЬ СУМЫН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 03 сарын 28 өдөр Дугаар 03 Сэвхүүл

Сумын Засаг даргын 2013-2016 онд
хэрэгжүүлэх үйл ажиллагааны
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Сумын Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил, жилийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж, биелэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жил тутамд тайлагнаж ажиллахыг Засаг дарга /Ч. Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.БАТЦЭНГЭЛ.

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

ЭРХЭМ ЗОРИЛГО: МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ СУМ БОЛНО. 2013.03.29

| Арга хэмжээний дугаар | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа он | Хэрэгжүүлэх байгууллага | Хөрөнгийн эх үүсвэр | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **НЭГ. АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН** | | | | |
| 1 | **1.1 "Нийгмийн хамгааллын бодлого"** | 1.1.1 | Суманд 300 ажлын байрыг шинээр бий болгон ажил орлогогүй өрх бүрийн нэг гишүүнийг түр болон байнгын ажлын байраар хангаж ажилгүйдлийн түвшинг бууруулах. | 2013-2016 | ЗДТГ НА | - | Өрхийн орлого нэмэгдэж, ажилгүйдэл буурна. |
| 2 | Ажилгүйдлийг бууруулж, зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлнэ. | 1.1.2 | Суманд ажил хайгч болон ЕБС төгсөгчдийг шаардлагатай мэргэжлээр суралцахад дэмжиж, зуучлалын сүлжээг бий болгох. | 2013-2016 | ЗДТГ НА | - | Ажиллах боловсон хүчнийг орон нутгаасаа бэлтгэж, төгсөгчид ажлын байраар хангагдана. |
| 3 | | 1.1.3 | Хагас, бүтэн өнчин хүүхдийг халамжлах, боловсрол мэргэжил олгох, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх. | 2013-2016 | ЗДТГ НА | УТ | Хагас, бүтэн өнчин хүүхдэд тавих хараа хяналт сайжирч, нийгмийн асуудлыг шийдсэн байна. |
| 4 | | 1.1.4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, албан байгууллагад хуулийн дагуу урамшуулал олгох. | 2013-2016 | ЗДТГ НА | УТ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажлын байраар хангагдаж, амьжиргааны түвшин дээшилнэ. |
| 5 | | 1.1.5 | Орлого багатай өрхөд ам бүлийн тоог үндэслэн нийгмийн халамж үйлчилгээг үзүүлэх. | 2013-2016 | ЗДТГ НА | УТ | Өрхийн амьжиргааг дэмжинэ. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | 1.1.7 | Ахмадын чийрэгжүүлэлтийн өрөөг тогтмол ажиллуулж, үйл ажиллагааг дэмжих. | 2014-2016 | ЗДТГ АХ | ОНХС | Ахмадын эрүүл мэнд сайжирч, нийгмийн идэвхи нэмэгдэнэ. |
| 8 | | 1.1.8 | Малчин болон ажилгүй иргэдийг эрүүл мэнд, сайн дурын нийгмийн даатгалд бүрэн хамруулах. | 2013-2016 | ЗДТГ НДБ | - | Малчин болон ажилгүй иргэдийн 80 хувийг хамруулна |
| 9 | | 1.1.9 | "Ажилгүйдлийг бууруулах арга зам" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх. | 201-2016 | ЗДТГ | - | Ажилгүйдэл буурч, хөтөлбөр хэрэгжинэ. |
| 10 | **1.2 ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**<br><br>Уул уурхай, дэд бүтэц, газарзүйн байршлын давуу талаа түшиглэн эдийн засгийн таатай орчинг бүрдүүлнэ. | 1.2.1 | 2030 он хүртэлх Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах. | 2013-2016 | ЗДТГ | УТ | Дэд бүтэц сайжирч ерөнхий төлөвлөгөө хэрэгжсэн байна. |
| 11 | | 1.2.2 | Орон нутагт эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд ээлтэй, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, шинээр ажлын байр бий болгосон /барилгын материал, утаагүй түлш гэх мэт/ үйлдвэр үйлчилгээг хөгжүүлэн дэмжин ажиллах. | 2013-2016 | ЗДТГ | СХС | Жижиг дунд үйлдвэрлэл хөгжиж, ажлын байр нэмэгдсэн байна. |
| 12 | | 1.2.3 | Төсөвт байгууллагуудын санхүүжилт түүнд гүйцэтгэлээр тавих хяналтыг сайжруулж, татварын орлогын бүрдүүлэлтэнд иргэн, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулж эдийн засгийн өсөлтийг хангах. | 2013-2016 | ЗДТГ | - | Орон нутгийн төсөв нэмэгдэнэ. |
| 13 | | 1.2.4 | "Шивээ-Овоо" ХК-ийн шинэчлэлийн ажлыг бодлогоор дэмжиж хамтарч ажиллах. | 2013 | ЗДТГ ШОХК | ХХО | Эдийн засаг, нийгмийн үзүүлэлт өснө. |
| 14 | | 1.2.5 | Босоо тэнхлэгийн авто замыг сайжруулсан замаар холбох. | 2013-2014 | ЗДТГ | УТХ | Дэд бүтэц сайжирч, засмал замтай холбогдсоор хөгжил дэвшил ирнэ. |
| 15 | | 1.2.6 | Сумын хэмжээнд гудамж, талбайн гэрэлтүүлгийг үе шаттайгаар нэмэгдүүлж, иргэдийн шинээр өмчилж авсан газарт цахилгаан эрчим хүчний шугам татах. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Иргэдийн ая тухтай, аюулгүй орчин бүрдэж, газар өмчилж авах иргэдийн тоо өснө. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | [illegible] орчин бүрдэнэ. |
| 17 | | 1.2.8 | ЕБС-ийн 640 хүүхдийн хичээлийн шинэ барилгын зураг төсвийг хийлгэж, сургуулийн барилгыг ашиглалтанд оруулж, сургуулийн дотуур барыг өргөтгөж тохижуулах. | 2013-2016 | ЗДТГ Су | ОНХС УТ | Суралцагчдын амьдрах болон сургалтын таатай орчин бүрдэнэ. |
| 18 | | 1.2.9 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн асуудлыг шийдвэрлүүлэн, хүчин чадлыг нэмэгдүүлэх. | 2014-2016 | ЗДТГ Цэ | ОНХС УТ | Сургалтын таатай орчин бүрдэж, хамран сургалтын тоо өсне. |
| 19 | | 1.2.10 | Соёлын төвийн барилгыг шинээр барих. | 2015-2016 | ЗДТГ СТ | УТ | Стандартын барилгатай болж, соёлын хүртээмж нэмэгдэнэ. |
| 20 | | 1.2.11 | Эрүүл мэндийн төвийн барилгыг өргөтгөх. | 2014-2016 | ЗДТГ ЭМТ | УТ | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна. |
| 21 | | 1.2.12 | Сумын төвийн хуучин барилгуудыг засах, амины орон сууц барих замаар 150 айлыг орон сууцтай болгож төрийн албан хаагчдыг төсөл хөтөлбөрт хамруулах. | 2014-2016 | ЗДТГ | ХХО ТХ | Орчин үеийн орон сууцанд тав тухтай амьдрах нөхцөл бүрдэж, иргэдийн нийгмийн асуудал шийдэгдсэн байна. |
| 22 | | 1.2.13 | "Илчлэг-Шивээ" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын халаалтын зуухны өргөтгөлийг шинээр барьж, халаалтын зууханд ялтсан бойлуур суурилуулах, 20 тонны өөрөө буулгагч ачааны автомашин, бохирын автомашин, жижиг оврын универсал экскаватортой болгох. | 2014-2016 он | ЗДТГ И.Ш | УТ ОНХС | Байгууллагын үйл ажиллагаа сайжирч, иргэдийн амьдрах орчин сайжирна. |
| 23 | | 1.2.14 | Нийтийн халуун усны байр барих. | 2013-2015 он | ЗДТГ | ОНХС | Стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн нийтийн халуун усны байртай болсоноор иргэд үйлчлүүлэх боломжтой болно. |
| 24 | | 1.2.15 | Сумын төвд стандартын шаардлага хангасан замын тэмдэг, тэмдэглэгээ бүхий засмал зам, явган хүний замтай болох. | 2014-2016 | ЗДТГ ШОХК | ОНХС ХХО | Авто замын аюулгүй байдал хангагдаж, тохижилт, дэд бүтэц сайжирна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | талбай бий болгох. | | | | бүрдэнэ. |
| 26 | | 1.2.17 | Суманд бохир цэвэрлэх байгууламж барих. | 2014-2016 | ЗДТГ ИШ | УТ ОНХС | Хөрсний бохирдол багасч, экологийн тэнцвэртэй байдал хадгалагдсан байна. |
| 27 | | 1.2.18 | Орон сууцны 3, 6, 7, 8-р байрны гадна ханын дулаалга, дээврийг засч, хэрэглээний халуун устай болгох. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Иргэдийн тав тухтай амьдрах нөхцөл сайжирна. |
| 28 | | 1.2.19 | Алсын худгийн дэргэд цэвэр усны нөөц худаг шинээр гаргах, урд гэр хороололд цэвэр усны шугам татах, ундны усны эх үүсвэрт ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах. | 2013-2016 | ЗДТГ ИШ | ОНХС | Хүн амыг стандартын шаардлага хангасан, баталгаатай ундны усаар хангана. |
| 29 | | 1.2.20 | Ахуйн үйлчилгээний төв байгуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулах. | 2013-2014 | ЗДТГ | УТ | Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байр нэмэгдэнэ. |
| 30 | | 1.2.21 | Цэцэрлэгийн гадна шугамын засвар хийх. | 2013-2014 | ЗДТГ | ОНХС | Хүүхдийн сурч боловсрох таатай орчин сайжирна. |
| 31 | | 1.2.22 | ЗДТГ-ын барилгын их засвар хийх. | 2014-2016 | ЗДТГ | УТ | Ажлын байрны орчин сайжирна. |
| 32 | **1.3 Хөдөө аж ахуйн бодлого** Хүн амын эрүүл аюулгүй хүнсний хангамжийг нэмэгдүүлэн ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлж экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангана. | 1.3.1 | "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хүрээнд өндөр ашиг шимт үүлдрийн мал үржүүлж, эрчимжсэн аж ахуй эрхлэхийг бодлогоор дэмжих. | 2014-2016 | ЗДТГ МЭҮТ | ОНХС | Өндөр ашигт эрчимжсэн мал аж ахуй хөгжсөн байна. |
| 33 | | 1.3.2 | Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжих. | 2013-2016 | ЗДТГ, МЭҮТ | ОНХС | Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ хангагдана. |
| 34 | | 1.3.3 | Мах махан бүтээгдэхүүн бэлтгэхийг дэмжиж мах нийлүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох. | 2013-2016 | ЗДТГ МЭҮТ | ОНХС | Эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр иргэдийн хэрэгцээг хангана. |
| 35 | Малын удмын санг хамгаалж, үржлийн бодлогыг шинэчлэн, өндөр ашиг | 1.3.4 | Малын удмын санг хамгаалах зорилгоор сайн чанарын хээлтүүлэгч бэлтгэх. | 2013-2016 | ЗДТГ, МЭҮТ | ОНХС | Хээлтүүлэгчийн тохироо бүрдэнэ. |
| 36 | | 1.3.5 | Мал сүргийг эрүүлжүүлэн цахим бүртгэлд оруулж, мэдээллийн санг бүрдүүлэх. | 2013-2016 | ЗДТГ МЭҮТ | УТ | Үхэр сүргийн 100%, Бог малын 50% нь мэдээллийн санд бүртгэгдсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлогоор дэмжинэ. | | тогтмолжуулж, чанаржуулах. | | | | |
| 39 | Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, сумын иргэд төмс, хүнсний ногооны хэрэгцээний 50-аас дээш хувийг тариалах | 1.3.8 | Усалгаатай тариалангийн талбайг 18 га-д хүргэж, өрхийн аж ахуйг дэмжин сумын төвийн хүн амын хүнсний ногооны хэрэгцээг хангах. | 2013-2016 | ЗДТГ МЭҮТ | УТ | Хүн амын хүнсний ногооны хэрэгцээний 50% хангагдсан байна. |
| 40 | | 1.3.9 | Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн хүнсний ногооны зоорийг ашиглах. | 2013-2016 | ЗДТГ МЭҮТ | ХХ | Иргэд эрүүл хүнсээр хангагдсан байна. |
| 41 | | 1.3.10 | Хөдөө аж ахуйн зориулалттай техник, тоног төхөөрөмжөөр хангаж малын тэжээл бэлтгэх. | 2013-2016 | ЗДТГ МЭҮТ | ТХ | Сумын хэмжээнд өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлнэ. |
| 42 | | 1.3.11 | Хөдөөгийн малчдыг сэргээгдэх эрчим хүчээр 100 хувь хангах. | 2013-2016 | ЗДТГ | ТХ | Малчдын ахуй нөхцөл сайжирна. |
| 43 | Бэлчээрийн доройтлыг бууруулж усан хангамжийг нэмэгдүүлнэ. | 1.3.12 | Улсын төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй болон энгийн уст цэгийг шинээр гаргаж, сэргээн засварлах. | 2013-2016 | ЗДТГ МЭҮТ | УТ | Бэлчээрийн усан хангамж нэмэгдэнэ. |
| 44 | | 1.3.13 | Бэлчээрийг зохистой ашиглах, талхлагдсан бэлчээрийг нөхөх сэргээх, хортон мэрэгчидтэй тэмцэх замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээж, ургамлын гарц нэмэгдсэн байна. |
| 45 | Малын гаралтай түүхий эд, бүтээгдхүүний зах зээлийг өргөжүүлж, Хөдөө аж ахуйн биржээр түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоог боловсронгуй | 1.3.14 | НЭГ БАГ- НЭГ ХОРШОО хөдөлгөөн өрнүүлж, өрхийн аж ахуй эрхлэх, загвар хоршоодыг бодлогоор дэмжих. | 2013-2016 | ЗДТГ МЭҮТ | УТ | Малчин өрх бүр хоршооны гишүүн болж үйл ажиллагаа жигдэрч, загвар хоршоо бий болсон байна. |
| 46 | | 1.3.15 | Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх биржийн үйл ажиллагааг дэмжих. | 2013-2016 | ЗДТГ МЭҮТ | УТ | Биржийн үйл ажиллагаа жигдэрч хуулийн хэрэгжилт хангагдсан байна. |
| 47 | | 1.3.16 | "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" үзэсгэлэн худалдааг үргэлжлүүлэн зохион байгуулж сумын брэнд бүтээгдэхүүнийг бий болгох. | 2013-2016 | ЗДТГ | - | Суманд брэнд бүтээгдэхүүнтэй болсон байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 49 | **2.1 Эрүүл мэндийн бодлого** | 2.1.1 | Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг өргөн хүрээтэй зохион байгуулж иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах. | 2013- 2016 | ЗДТГ ЭМТ | УТ | Иргэдийн ЭМ-ийн боловсрол дээшилж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж хүн амын ЭМ-ийн индекс сайжирна. |
| 50 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг | 2.1.2 | Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сантай болж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах. | 2013- 2016 | ЗДТГ ЭМТ | ОНХС | Орон нутгийн эрүүл мэндийн нэгдсэн сан бий болж, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. |
| 51 | сайжруулж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр | 2.1.3 | Эмч эмнэлгийн ажилтанг мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтанд шат дараатай хамруулах. | 2013- 2016 | ЗДТГ ЭМТ | УТ | Иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар сайжирна. |
| 52 | хангана. | 2.1.4 | Хорт зуршил, хөдөлгөөний хомсдол ба эрүүл бус хүнсний хэрэглээг бууруулах, бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлж, эрүүл мэндийн боловсролын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | 2013- 2016 | ЗДТГ ЭМТ | УТ | Эрүүл мэндийн боловсрол дээшилж, хөтөлбөр хэрэгжсэн байна. |
| 53 | | 2.1.5 | Стандартын шаардлага хангасан эмийн санг бодлогоор дэмжиж хүртээмжтэй эмээр иргэдэд үйлчлэх. | 2013-2016 | ЗДТГ ЭМТ | ХХО | Эмийн хэрэгцээг хангасан эмийн сангийн зах зээлийн өрсөлдөөнийг бий болгосноор иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлнэ. |
| 54 | | 2.1.6 | Эмчилгээ үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, өвчлөлийг бууруулах зорилгоор улирлын чанартай сувилал ажиллуулах. | 2014-2016 | ЗДТГ ЭМТ | ТХ ЖДҮХС | Хүн амын суурь өвчлөл буурна. |
| 55 | | 2.1.7 | Стандартын шаардлага хангасан нийтийн биеийн тамирын талбайтай болох, нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгож төрөл бүрийн секц, дугуйлан хичээллүүлэх. | 2014-2016 | ЗДТГ | ОНХС | Нийтийн биеийн тамирыг хөгжүүлснээр иргэд чөлөөт цагаа зөв боловсон, ая тухтай өнгөрүүлнэ. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлого | | сургалтанд хамруулах. | | | | |
| 57 | Боловсролын сургалтын орчинг бүрдүүлж, стандарт хангалтын чанарыг сайжруулна. | 3.1.2 | Сургуулийн өмнөх насны хүүхдийн тоглоом наадгайн хангамжийг сайжруулах. | 2013-2016 | Цэ | ОНТ | Хүүхдийн сурах орчин сайжирна. |
| 58 | | 3.1.3 | Төсвийн байгууллагуудын гадна орчинд ногоон төгөл байгуулах | 2013-2016 | Тө бай | ОНТ | Байгууллагуудын гадна орчны өнгө үзэмж сайжирна. |
| 59 | | 3.1.4 | Багшлах боловсон хүчний ур чадварыг сайжруулж "Багш", "Авъяас", "Ном" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. | 2013-2016 | ЗДТГ | ОНТ | Багшлах боловсон хүчний хүрэлцээ сайжирч, сургалтын дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэн хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байна. |
| 60 | | 3.1.5 | ЕБС-ын суралцагчдын сургалтын стандарт хангалтын чанарыг сайжруулах. | 2013-2016 | Су | - | Суралцагчид нь улс, аймгийн дундажаас дээгүүр түвшинг хангасан байна. |
| 61 | | 3.1.6 | Сургуулийг интернетэд холбож, багш, суралцагчдыг мэдээ, мэдээллээр хангах, сургалтын дэвшилтэт арга зүй технологийг туршин нэвтрүүлэх. | 2013-2016 | Су | УТ | Багш, суралцагчид мэдээллээр хангагдаж, сургалтын арга барил дээшилнэ. |
| 62 | **Соёл урлаг**<br>Соёл урлагын байгууллагын үйлчилгээний чанарыг дээшлүүлж, уламжлалт соёлын өвийг баяжуулан хөгжүүлнэ. | 3.1.7 | Соёлын үйлчилгээг сайжруулах. | 2013-2016 | ЗДТГ СТ | ОНТ | Иргэдэд соёлын үйлчилгээг ойртуулж, тэдний урлаг соёлын ажилд оролцох нөхцөл бүрдэнэ. |
| 63 | | 3.1.8 | Иргэдэд уйгын бичиг хөтлөх арга зүйн талаарх сургалт зохион байгуулах, уйгын бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлэх. | 2013-2016 | ЗДТГ СТ | ОНТ | Нийт өрхийн 40 хувийг уйгын бичиг хөтөлдөг болсон байна. |
| 64 | | 3.1.9 | Соёлын төвийн дэргэдэх орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг сайжруулж тогтмолжуулах. | 2013-2016 | СТ | УТ | Түүх, өв соёл, ёс заншилыг харуулсан цогц танхимаар иргэд үйлчлүүлнэ. |
| 65 | | 3.1.10 | Соёлын төвийн цахим номын сангийн үйл ажиллагааг тогтмолжуулах. | 2013-2016 | СТ | УТ | Уншигчдын тоо нэмэгдэж, мэдээллээр хангагдана. |
| 66 | | 3.1.11 | Ардын урлагийн өв соёлыг хөгжүүлэх. | 2013-2016 | СТ | УТ | Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орчны бодлого | | хэрэгжүүлэх. | | | | хөтөлбөр хэрэгжсэн байна. |
| 68 | Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдолыг зогсоож хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | 4.1.2 | Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг сайжруулж тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Түүх соёлын дурсгалт газрын хамгаалалт сайжирна. |
| 69 | | 4.1.3 | Сумын төвд цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж шинээр бий болгох. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Иргэдийн амьдрах таатай орчин, тохижилт өнгө үзэмж сайжирна. |
| 70 | | 4.1.4 | Байгаль орчныг хамгаалах, байгалийг нөхөн сэргээх ажилд иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог өргөжүүлэх. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Иргэн, ААН, төрийн болон ТББ-ын хамтын ажиллагаа сайжирна. |
| 71 | | 4.1.5 | Сумын хэмжээнд байгаа балгас туурийн хэмжээг 50 хувиар багасгаж, ахуйн болон хог хаягдлын менежментийг сайжруулах. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэж хоггүй цэвэр сум болсон байна. |
| 72 | | 4.1.6 | Суманд аюултай хог хаягдлын тусгай цэг бий болгох, төвлөрсөн хогийн цэгийг тохижуулж, хог хаягдал булшлах ландфиллийн аргыг хэрэгжүүлэх. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Хог хаягдлыг устгах менежмент нэвтэрсэн байна. |
| 73 | | 4.1.7 | Булаг шандын эхийг хамгаалах, байгалийн унаган төрхийг нөхөн сэргээх ажлыг сайжруулах. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Булаг, шанд ширгэхээс хамгаална, булгийн ундарга нэмэгдсэн байна. |
| 74 | | 4.1.8 | Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавьж, нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу чанартай гүйцэтгүүлэх. | 2013-2016 | ЗДТГ | ХХО | Нөхөн сэргээлтийн ажил стандартын дагуу хийгддэг болно. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө | | | 2013-2016 | ЗДТГ | ОНТ | шуурхай үйлчилсэн байна. |
| 76 | боловсруулан батлуулж, газрын харилцааны шинэтгэлийг эрчимжүүлнэ. | 4.1.10 | Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулийн дагуу дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчимаар олгох. | | | | Иргэд өмчтэй болж, аймаг орон нутгийн орлого нэмэгдэнэ. |
| 77 | **Нийгмийн аюулгүй байдал** | 4.1.11 | Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг бататгахад чиглэсэн дадлага, сургалтыг явуулах. | 2013-2016 | ЗДТГ ОБХ | ОНХС | Иргэд болзошгүй аюулаас хамгаалах анхан шатны мэдлэгтэй болсон байна. |
| 78 | Аюулгүй байдлыг хангах, архидан согтуурах болон малын | 4.1.12 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх. | 2013-2016 | ЗДТГ ЦТ | ОНТ | Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж, амгалан тайван амьдрах орчин бүрдэнэ. |
| 79 | хулгайтай тэмцэх ажлыг иргэн, ААНБ-тай | 4.1.13 | "Архигүй монгол хүн" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах. | 2014-2016 | ЗДТГ ЦТ | ОНТ | Архидалт багассан байна. Архи худалдан борлуулах цэгийн тоо буурсан байна. |
| 80 | хамтран зохион байгуулна. | 4.1.14 | Малын хулгайтай тэмцэх асуудлын хүрээнд байнгын ажиллагаатай цахим сүлжээ бий болгох бэлтгэл ажлыг хангах. | 2013-2016 | ЦТ | УТ, ТХө | Цахим сүлжээтэй болсноор малын бүртгэл мэдээллэлтэй болно. |

## ТАВ: ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 81 | **5. Засаглалын шинэчлэлийн бодлого** Төрийн үйлчилгээг иргэдийн | 5.1 | Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгож зөвлөгөө, мэдээлэл өгөх "Иргэний танхим"-ыг байгуулж суманд хийгдэж буй хөрөнгө оруулалт, жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, газрын харилцаа, иргэний бүртгэл зэрэг ажлыг иргэдэд нээлттэй "Иргэнд ойрхон төр"-ийг бий болгох. | 2013-2016 | ЗДТГ | ОНХС | Иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах, тэдний санал хүсэлтийг хүлээн авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. |
| 82 | оролцоонд тулгуурласан нээлттэй, тунгалаг болгох | 5.2 | Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх. | 2013-2016 | ЗДТГ | ОНТ | Иргэдэд төрийн үйлчилгээг чанартай хүргэнэ. |